

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.07.22-07.26

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өнгөрсөн долоо хоногын уналтаасаа сэргэн, S&P 500 болон Nasdaq индексүүд түүхэн дээд ханшид хүрч хаагдлаа.

"Google" компанийн толгой компани болох "Alphabet" компанийн хувьцааны ханш 10 хувиар өссөнөөр Nasdaq индекст эерэгээр нөлөөлжээ. Тус компанийн 2-р улирлын ашиг таамаг хэмжээнээс өндөр гарч, мөн компани өөрийн 25 тэрбум ам.долларын хувьцаагаа халааслах төлөвлөгөөтэй байгаа талаар мэдээлсэн юм.

"Alphabet" болон "Twitter" компаниудын ашиг нэмэгдэж, нэгж хувьцааны ханш өссөнөөр S&P 500 индексийн сагсанд багтдаг харилцаа холбооны салбарын компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна. Уолл Стритийн шинжээчид S&P 500 индексийн сагсанд багтаж буй компаниудын орлого өнгөрсөн жилийн мөн үетэй төстэй байна гэсэн хүлээлттэй байгаа ч эхний хагас жилийн тайлангууд олон нийтэд ил болохын хэрээр олон компаниудын ашиг шинжээчдийн таамгаас өндөр байгаа аж.

"IHS Markit" байгууллагын судалгаагаар 6-р сард АНУ-ын аж үйлдвэрийн идэвх буурч 50 нэгжтэй тэнцжээ.

Ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо огцом буурч, сүүлийн 3 сарын доод хэмжээнд хүрэв.

Энэ сарын 30-31-ний өдрүүдэд болох Холбооны нөөцийн сангийн хуралдаанаар бодлогын хүүг 0.25%-аар бууруулна гэсэн хүлээлт хөрөнгө оруулагчдын дунд хэвээр үлджээ. Ингэснээр 10 жилийн хугацаатай АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж бага зэрэг өслөө.

**Европ:** Хувьцаат компаниудын ашигт ажиллагаа сайжирч, Европын төв банк эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого баримталж байгаа нь Европын бүсийн хөрөнгийн зах зээлд өсөлтөд нөлөөлөв.

Европын төв банк 2016 хойш анх удаагаа богино хугацаат бодлогын хүүгээ бууруулна гэсэн дохиог зах зээлд өгснөөр еврогийн ханш ам.долларын эсрэг сулрав. Тус байгууллагын тэргүүн ноён Марио Драгигийн үзэж байгаагаар энэхүү бодлого нь тус бүс нутгийн эдийн засгийн зогсонги байдлыг идэвхжүүлэх, "Brexit"-ийн хэлэлцээрийн сөрөг нөлөөг зөөллөхөд чиглэсэн ажээ. Их Британийн дараагийн Ерөнхий сайдаар Борис Жонсон сонгогдсоноос үүдэн фунтийн ханш ам.долларын эсрэг сулрав. Борис Жонсон Европын холбооноос хэлцээргүй гарахыг дэмжиж байгаа.

**Япон:** Хөрөнгө оруулагчид АНУ-ын Холбооны нөөцийн сангийн мөнгөний бодлогын хуралдааны өмнөхөн буюу 7 сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулагдах Японы төв банкны мөнгөний бодлогын хуралдааныг хүлээж байна. Тус хуралдаанаар АНУ-ын Холбооны нөөцийн сангийн шийдвэр Япон улсын зах зээлд хэрхэн нөөлөхийг хэлэлцэх юм.

Ройтерс агентлагийн шинжээчдийн үзэж байгаагаар Японы төв банк бодлогын хүүг бууруулахгүй ба цаашид урт хугацаанд хүүг маш доогуур түвшинд барих бодлого хэрэгжүүлэх аж.

**БНХАУ:** Ирэх долоо хоногт АНУ, БНХАУ хоорондын дээд түвшний худалдааны уулзалт тохиож байгаатай холбоотойгоор Хятадын хувьцаат компаниудын хувьцааны ханш өсөлт үзүүлээ. Хэдийгээр худалдааны хэлэлцээрүүд зохион байгуулагдаж байгаа нь сайн хэрэг боловч шинжээчид ойрын хугацаанд хоёр улсын худалдааны маргааны асуудалд ямар нэгэн ахиц гарахгүй гэж үзэж байна.

**Эх сурвалж:** Troweprice.com

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,233.74	-1.84% ▼
Dow Jones	АНУ	27,192.45	0.14% ▲
S&P 500	АНУ	3,025.86	1.65% ▲
Nasdaq	АНУ	8,330.21	2.26% ▲
S&P/TSX	Канад	16,531.04	0.27% ▲
FTSE 100	Их Британи	7,549.06	0.54% ▲
S&P/ASX 200	Австрали	6,793.40	1.33% ▲
Nikkei 225	Япон	21,658.15	0.89% ▲
Hang Seng	Хонг Конг	28,397.74	-1.28% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.63
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	102.23
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	101.15
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	110.90
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.88
DBM' 2023	USD	7.250%	104.94
TDBM' 2020	USD	9.375%	103.51

### Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.237	-0.02 ▼
Libor 3M	2.265	0.01 ▲
Libor 6M	2.200	0.06 ▲
Libor 1YR	2.196	0.04 ▲
US 2YR Bond	1.844	0.03 ▲
US 3YR Bond	1.807	0.02 ▲
US 5YR Bond	1.840	0.03 ▲
US 10YR Bond	2.063	0.02 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2019.07.26	Өөрчлөлт
USD	2,665.32	0.13% ▲
CNY	387.47	0.06% ▲
EUR	2,968.50	-0.99% ▼
RUB	42.21	-0.26% ▼
KRW	2.25	-0.88% ▼
JPY	24.53	-0.81% ▼
CAD	2,022.78	-0.96% ▼

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,418.90	-0.45% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	16.40	1.24% ▲
Зэс	USD/lb.	268.50	-2.45% ▼
Нүүрс	USD/MT	74.07	-2.00% ▼
WTI газрын тос	USD/bbl.	56.20	1.02% ▲
Brent газрын тос	USD/bbl.	63.46	1.58% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.17	-3.56% ▼

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VI	8.10%
Бодлогын хүү	2019. VI	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VI	11.13%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VI	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VI	4.95%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VI	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VI	10.68%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 43 компанийн 338.5 сая төгрөгийн 1,748,070 ширхэг хувьцаа арилжаалагдав.


“Монгол базальт” /MBW/ компанийн хувьцаа 13.21%-аар буюу хамгийн ихээр өсөж 360.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Нако түлш” /NKT/ компанийн хувьцаа 25.00%-аар буурч 60.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 104 ширхэг үнэт цаас 10.4 сая төгрөгөөр арилжаалагджээ.


7-р сарын 26-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,488.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,233.74 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 1.84%-аар буурсан байна.

## MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



\*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	348.9
Зах зээлийн үнэлгээ	2,488,764.6

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,233.74	-1.84% ▼
MSE I индекс	8,924.99	-7.06% ▼
MSE II индекс	8,169.66	-0.21% ▼

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Монгол базальт	377,192	134,383,208
Лэндмн ББСБ	494,119	30,410,078
Говь	90,110	25,997,225
Монос хүнс	338,708	23,665,698
АПУ	36,412	20,499,483

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол базальт	360.00	13.21% ▲
Хишиг уул	450.00	12.50% ▲
Талх чихэр	18,500.00	8.82% ▲
Монгол савхи	650.00	8.33% ▲
Инвескор ББСБ	1,816.00	2.95% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Нако түлш	60.00	-25.00% ▼
МИК холдинг	11,020.00	-24.00% ▼
Хай би ойл	47.10	-15.89% ▼
Техник импорт	10,200.00	-14.86% ▼
Цагаантолгой	1,625.00	-14.47% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Гаули	138,507,311
БиДиСек	115,466,866
Голомт Капитал	102,119,349
Бумбат-Алтай	61,439,138
Стандарт инвестмент	60,467,865

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	569.00	605,519
Таван толгой	7,015.00	369,446
МИК Холдинг	11,020.00	228,217
Говь	284.25	221,747
Инвескор ББСБ	1,816.00	130,258

## ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-15/08/20-A0295-14.5	104	10,400,000	100,000	100,000	156	14.500%

## НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дүти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Түмэн шувуут” компанийн цэвэр ашиг 72.3%-аар өсөж, хөрөнгө оруулагчдын хүлээлтэд хүрэв

Энэ оны 2-р сард хөрөнгийн зах дээр амжилттай IPO гаргасан Түмэн шувуут /MSE:TUM/ хувьцаат компанийн эхний хагас жилийн тайлан гарлаа.

Эхний хагас жилийн байдлаар тус компани 31.5 сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.8 сая ширхгээр буюу 27.5%-аар өссөн байна.

Компани энэ онд борлуулалтаа нэмэгдүүлэх ажлын хүрээнд харилцагчдын тоог 20%-аар нэмэгдүүлж 2,400-л хүргэхээр зорьж байгаа.

Санхүүгийн үзүүлэлтийг харвал “Түмэн шувуут” ХК нь эхний хагас жилд 10.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 2.1 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаандаа EPS = 10.34 төгрөгийн ашигтай ажилласан байна. Мөн борлуулалтанд эзлэх ашгийн хувь хэмжээ өссөн дүнтэй гарав.

Харин дээрх үзүүлэлтийг 2018 оны мөн үетэй харьцуулбал, борлуулалтын орлого 2.16 тэрбум төгрөг буюу 26%-аар, цэвэр ашиг 0.87 тэрбум төгрөг буюу 72.3%-аар тус тус өсжээ.

“Түмэн шувуут” ХК нь хувьд 2019 онд 17.3 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 2.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөөд байсан бол хагас жилийн гүйцэтгэлээр борлуулалт 60.4%-тай, цэвэр ашиг 79.5%-ийн гүйцэтгэлтэй гарсныг энд онцлох хэрэгтэй.

Олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн тухайд товч дурдвал:

- “Өндөглөгч тахианы аж ахуй”-н өргөтгөлийн ажил 80%-тай /Барилгын ажил дуусаж, тоног төхөөрөмжөө байрлуулах ажил явагдаж байгаа/;

- “Газар тариалан, гурил тэжээлийн үйлдвэр”-ийн ажлын хүрээнд хийгдсэн усалгааны тоног төхөөрөмжийн угсралтын ажил 95%-тай;

- Сангасны органик бордооны үйлдвэрийн ажил 50%-тай / 9-р сард ашиглалтад оруулахаар ажиллаж байгаа /;

- Махны чиглэлийн тахианы аж ахуйн барилгын ажил 20%-ийн гүйцэтгэлтэй байгаа талаар компаниас мэдэгдлээ.

Мөн компанид хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын тоо тогтмол нэмэгдэж, компанийн санхүүгийн үзүүлэлт хөрөнгө оруулагчдын эерэг хүлээлтэнд хүрч, өндөр үзүүлэлттэй гарсан нь цаашид ханш өсөх нөхцөл бүрдэж байна гэж үзэхээр байна.

**Эх сурвалж:** MarketInfo.mn

### “Адуунчулуун” компани 1.6 тэрбум төгрөгийн алдагдал хүлээв

Зүүн бүсийг эрчим хүчний нүүрсээр хангагч “Адуунчулуун” ХК /MSE:ADL/ компани 2019 оны эхний хагас жилийн байдлаар -1.6 тэрбум төгрөгийн алдагдал хүлээлээ.

Тайлант хугацаанд тус компани 1.9 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан боловч 3.3 тэрбум төгрөгийн өртөгтэй ажилласан нь ийнхүү алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.

Харин компанийн борлуулалтын орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал -54%-аар буурчээ.

Хувьцааны ханшийн тухайд оны эхээс 499 төгрөгөөр буюу 23.8 хувиар буурч 1,601 төгрөгт хүрээд байна.

**Эх сурвалж:** MarketInfo.mn

### “Говь” компанийн өр төлбөр 2 дахин өсжээ

ТОП-20 индексийн сагсанд багтаж буй Говь /MSE:GOV/ хувьцаат компани 2019 оны эхний хагас жилд 3.9 тэрбум төгрөг буюу нэгж хувьцаандаа EPS=5.11 төгрөгийн ашигтай ажилласан байна.

Ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 291 сая төгрөг буюу 6.8%-аар буурсан үзүүлэлттэй гарав. Борлуулалтын орлогын тухайд тайлант хугацаанд 66.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 11.2 тэрбум төгрөг буюу 20.1%-аар өсжээ.

“Говь” ХК-ийн өр төлбөр их хэмжээгээр нэмэгдсэн нь хөрөнгө оруулагчдын анхаарлыг ихээр татаж байна. Хагас жилийн байдлаар тус компани 320.3 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байгаа нь 2018 оны мөн үеэс 2 дахин өсжээ. Компанийн урт хугацаат зээл 84.5 тэрбум төгрөг, богино хугацаат зээл 168.5 тэрбум төгрөгтэй тэнцжээ. Үүнээс, богино хугацаат зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3 дахин нэмэгдэж, 113.0 тэрбум төгрөгт хүрсэн байна.

“Говь” ХК нь “Гоёо” ХХК-ийг 15 сая ам. доллароор худалдан авах шийдвэр гаргаад удаагүй байгаа билээ

**Эх сурвалж:** MarketInfo.mn

### “Сүү” компанийн цэвэр ашиг 1.99 тэрбум төгрөгөөр өсжээ

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Сүү” /MSE:SUU/ хувьцаат компани 2019 оны хагас жилийн санхүүгийн тайлангаа танилцуулав.

Эхний хагас жилд компани 37.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 4.19 тэрбум төгрөгийн буюу нэгж хувьцаандаа EPS = 12.17 төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Тайлангийн үзүүлэлтийг 2018 оны мөн үетэй харьцуулбал, орлогын хэмжээ 2.12 тэрбум төгрөг буюу 6.0%-аар, ашиг 1.99 тэрбум төгрөг буюу 90.7%-аар тус тус өссөн байна.

Харин өр төлбөрийн тухайд урт хугацаат зээл 12.1 тэрбум төгрөгөөр өсөж, 20 тэрбум төгрөгт хүрсэн бол богино хугацаат зээл 5.6 тэрбум төгрөгөөр буурч 6.4 тэрбум төгрөг болов.

**Эх сурвалж:** MarketInfo.mn

### “Баянгол зочид буудал” компани 4.5 сая төгрөгийн ашиг олж, 99.4%-аар буурчээ

МХБ-ийн үнэт цаасны I ангилалд бүртгэлтэй “Баянгол зочид буудал” /MSE:BNG/ компани 2019 оны эхний хагас жилд 2.1 тэрбум төгрөгийн орлого олж, 4.5 сая төгрөгийн ашигтай ажилласан талаараа тайлагнав.

Компанийн орлогын хэмжээ 2018 оны эхний хагас жилээс 9.8%-аар буурсан үзүүлэлттэй байгаа бол ашиг 99.4%-аар буурчээ.

Компанийн ашигт ажиллагаа буурахад борлуулалтын өртөг нэмэгдсэн нь гол нөлөөг үзүүлсэн бөгөөд өнгөрөгч онд тус компанийн борлуулалтын өртөг 61%-тай тэнцэж байсан бол энэ жил 81% болж нэмэгдсэн байна.

**Эх сурвалж:** MarketInfo.mn

### “Адуунчулуун” ХК-ийн 2018 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршууллаа.

“Адуунчулуун” ХК-ийн 2018 оны ногдол ашиг болох нэгж хувьцаанд 1117 төгрөг (татварын дараах) хуваарилсныг 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршууллаа.

**Эх сурвалж:** Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Тавантолгой-Гашуунсухайтын төмөр замын ажлыг ирэх сараас үргэлжлүүлнэ

2019 оны 7-р сарын 24-ны өдөр болсон Засгийн газрын ээлжит хуралдаанаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 208.5 км төмөр замын барилгын ажлыг 2019 оны 8-р сарын 15-ны өдрөөс үргэлжлүүлж, 2021 онд ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д олгож, суурь бүтэц, барих, ашиглахад шаардагдах хөрөнгийг тухай бүр техник, эдийн засгийн үндэслэлд заасан дүнгээр нүүрс урьдчилан борлуулах болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлж байхаар шийдвэрлэв.

Мөн инженерийн байгууламж, эрчим хүч, усан хангамж, өртөө, зөрлөгийн болон дохиолол холбоо, бусад барилга байгууламж барихад шаардагдах зөвшөөрлийг тухай бүр нь шуурхай олгож байхыг Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатарт үүрэг болгов.

"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн хувьцааны 66 хувийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-д, 34 хувийг "Монголын төмөр зам" ТӨХК-д эзэмшүүлэхийг холбогдох сайд, агентлагийн дарга нарт даалгалаа. Олон жил яригдсан дээрх чиглэлийн төмөр замыг тогтоосон хугацаанд нь барьж ашиглалтад оруулахыг Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх холбогдох сайд, агентлаг, компанийн удирдлагуудад онцгойлон анхааруулав.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам нь Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутгаар дайран өнгөрөх бөгөөд 30 сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрс тээвэрлэн экспортлох боломжтой.

2013-2015 онд замын доод бүтцийн ажлын 51.8 хувь, газар шорооны ажлын 86.6 хувь, гүүр, хоолойн ажлын 52 хувийг хийж гүйцэтгэсэн. Гэсэн ч санхүүжилтгүйн улмаас 2015-2018 онд ажил нь зогсоод байсан юм.

Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэл авто замаар нүүрс тээвэрлэхэд өртөг нь тонн тутамд 30-32 ам доллар байдаг. Төмөр замтай болсноор үнэ хоёр дахин буюу 14.9 ам.доллар болж буурах юм гэж Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс мэдээллээ.

**Эх сурвалж:** MongolianMiningJournal.com



## БУСАД МЭДЭЭ

Гадаад валютын нөөц 4 тэрбум ам.долларт хүрчээ

Монгол Улсын мөнгө, санхүүгийн статистик тойм мэдээллийг Монголбанкнаас танилцууллаа.

Төвбанкны судалгаа, статистикийн газрын захирал Б.Батдаваагийн танилцуулснаар, мөнгөний нийлүүлэлт буюу М1 өнгөрсөн 6-р сарын байдлаар 20.2 их наяд хүрээд байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар өссөн үзүүлэлттэй юм. Харин өмнөх сараас 0.3 хувь буюу 71 тэрбум төгрөгөөр буурчээ. Мөнгөний нийлүүлэлт өмнөх сараас буурахад төгрөгийн хадгаламж 350 тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Мөнгөний нийлүүлэлтийг эх үүсвэр талаас авч үзэхэд, 54.1 хувийг төгрөгийн хадгаламж, 17.1 хувийг төгрөгийн харилцах, 14.5 хувийг валютын хадгаламж, 11.2 хувийг валютын харилцах эзэлж, үлдэх 3.2 хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.

Банкуудын зээлийн үлдэгдэл 6-р сарын байдлаар 18.1 их наяд төгрөгт хүрээд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 18 хувиар өссөн үзүүлэлт юм. Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 26 хувиар өсөж, 9.4 их наяд төгрөгт хүрсэн бол хувийн байгууллагынх 10 хувиар өсөж, 8.5 их наяд төгрөгт хүрчээ. Нийт зээлийн 14 хувийг иргэдийн зээл, 1.6 хувийг байгууллагын зээл, 27 хувийг гадаад валютын зээл эзэлж, үлдсэнийг бусад зээл эзэлж байна. Өнгөрөгч сард банкууд 2.1 их наяд төгрөгийн зээл олгож, 1.8 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийн эргэн төлөлтийг хүлээн авсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн 10.6 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ өмнөх сарынхаас 0.5 хувиар буурсан үзүүлэлт аж. Хугацаа хэтэрсэн зээл нийт зээлийн 4.1 хувьтай байна.

Зээлийн үлдэгдлийг эдийн засгийн салбараар нь танилцуулбал уул уурхай болон боловсруулах салбар нийт зээлийн үлдэгдлийн тус бүр 16 хувийг эзэлж байна. Үүний дараа барилга 18 хувь, худалдааны салбар 24 хувийг эзэллээ. Иргэдэд олгосон нийт зээлийн үлдэгдлийн 37 хувийг ипотекийн зээл, 34 хувийг цалин, тэтгэврийн зээл эзэлж байна.

Өнгөрөгч сард банкууд нийт 780 зээлдэгчид 58.3 тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгосны 46 хувийг хөтөлбөрийн санхүүжилтээр, 54 хувийг банкууд өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) 11.2 хувьтай тэнцэж байгаа нь өмнөх сараас 0.1, өмнөх оны мөн үеэс нэг хувиар буурсан үзүүлэлттэй байна. Иргэдээс татсан хадгаламжийн ЖДХ 11.3 хувьтай, хувийн байгууллагаас татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ 11.0 хувьтай байна.

Төлбөрийн тэнцэл 6-р сарын байдлаар 456 сая ам.долларын ашигтай гарчээ. Үүнд Төлбөрийн тэнцлийн урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 136 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ. Үүнд манай улсын экспорт эхний зургаан сарын байдлаар 10 хувь өссөн нь голлон нөлөөлжээ. Ингэснээр Монгол Улсын гадаад валютын улсын нөөц дөрвөн тэрбум ам.долларт хүрч буй юм.

**Эх сурвалж:** Montsame.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.